

АЗИ-НАРАН УРГАХ НУТАГ

*Л.Бэгзжав
ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан,
доктор, профессор*

Ази, Европ гэдэг хоёр үг эртний семит хэлнийх юм. Барагцаалбал, 4000 жилийн өмнө амьдарч байсан Газрын дундад тэнгисийн зүүн эргийн семит үндэстэн феникчүүд эрэг орчимдоо хүчирхэг үндэстэн байв. Тэд уугуул нутаг газраа төв болгон, Газрын дундад тэнгисийн дорнод хэсгийг Ази, баруун хэсгийг Европ гэж нэрлэжээ. Семит хэлэнд Ази гэдэг бол “нар хөөрөх”, “дорноо нар мандах” гэсэн утгатай бол Европ гэдэг нь “нар жаргах”, “баруунаа нар шингэх” гэсэн утгатай байгаад аажимдаа хоёр тивийн нэр болсон байна.

Зарим түүхчдийн үзэхээр Ази, Европ гэсэн үгийн гарал нь Тигр, Евфрат хоёр мөрний сав газар дахь боолын байгуулалтай Ассир улсын ассир хэлний Asu, Ereb юм. Эртний венецчүүдийн худалдааны хөлөг онгоц Газрын дундад тэнгист аялж, тэнгисийн зүүн эргийн улсуудыг Asu, баруун талын улсуудыг Ereb гэдэг байжээ. Asu гэдэг нь нар мандах, дорно зүг, дорно дахин, Ereb гэдэг нь нар жаргах, өрнө зүг, өрнө дахин гэсэн утгатай бөгөөд хожмын хүмүүс Asu-г Asia гэж дуудах болжээ.

Мөн зарим мэдээгээр эртний грекчүүд зүүн талын улс орноо нийтэд нь Ази гэж үздэг байжээ. Мөн бага Азийн Баруун хэсгийн Грекийн хотын нэр өргөжсөөр бага Ази, Азийн бусад хэсгийг хамарсан гэж ч ярьдаг. МЭӨ I зуунд Ромын нэг мужийг Ази гэж нэрлэж байснаа хожим тивийн нэр болсон гэсэн мэдээ ч бий.

МЭ IV зууны эхээр Уралын нурууг хоёр тивийн хилийн зааг гэж үзэх болж, Уралын нурууны зүүн хэсгийг Ази, баруун хэсгийг Европ гэж нэрлэх болжээ.

Түүхийн эх сурвалж өөр өөр боловч Ази гэдэг нь аль ч хэлнээ наран ургах нутаг, дорно дахин гэсэн утгатай байна.

Дэлхийн бөмбөрцөг дээр Ази-Европ, Америк, Умарт Америк, Өмнөд Америк, Өмнөд туйл, Австрали гэсэн 6 том хуурай газар байна. Эх хуурай газар болон түүний ойролцоох арал, хойгийг нийтэд нь тив гэж нэрлэх ба өнөөгийн газар зүйчид дэлхийг Ази тив, Африк тив, Умарт Америк тив, Өмнөд Америк тив, Өмнөд туйлын тив, Европ тив, Их далайн тив гэж 7 тивд хуваах болжээ. Бидний дунд сургуульд үзэж байсан 5 тивийн тухай газар зүйн ойлголт өргөжсөн нь эндээс харагдана.

Ази тив дэлхийн хамгийн том тив бөгөөд 44 сая км² газар нутагтай, дэлхийн хуурай газрын нийт талбайн гуравны нэг буюу 29,4%-ийг эзэлдэг нь Хойт Америкийн нутаг дэвсгэрээс 2 дахин, Европоос 4 дахин том гэсэн үг.

Азид одоо 49 улс байгаа ба газар зүйн хувьд Зүүн Ази, Зүүн Өмнөд Ази, Өмнөд Ази, Баруун Ази, Төв Ази, Умарт Ази гэж 6 хуваадаг.

Зүүн Азид Монгол, Хятад, Умарт Солонгос, Өмнөд Солонгос, Япон улс (5), Зүүн Өмнөд Азид Вьетнам, Лаос, Кампучи, Мьянма, Тайланд, Бруней, Малайз, Сингапур, Зүүн Тимор,

Филиппин, Индонез (11), Өмнөд Азид Энэтхэг, Пакистан, Бангладеш, Балба, Сикким, Бутан, Шриланка, Мальдив(8), Баруун Азид Афган, Иран, Ирак, Саудын Араб, Йемэн, Оман, Арабын нэгдсэн Эмирт, Катар, Бахрейн, Турк, Сири, Кувейт, Йордан, Израйль, Ливан, Кипр, Гүрж, Армен, Азербайжан, Пакистан (20), Төв Азид Казак, Кыргыз, Тажик, Туркмен, Узбек (5) улс багтах ба Умарт Азид Оросын Азийн хэсгийн Сибирийн бүс нутаг хамаарна. Азид хамгийн том газар нутаг, хүн ам олонтой нь Хятад бол хамгийн бага нутаг, цөөн хүн амтай нь Мальдив юм.

Далайн түвшнээс дээш дунджаар 960 метр өндөрт орших Ази тивийн газар нутгийн 75% нь өндөрлөг тал, өндөр уулс, 25% нь тэгш тал бөгөөд “дэлхийн дээвэр” гэж нэрлэгддэг Хөх нуур-Төвдийн өндөрлөг гэхэд далайн түвшнээс дээш дунджаар 4500 м, Гималайн уулс 6000 м өндрөөс давдаг бол 8000 метрээс дээш өндөртэй 14 оргил байдаг. Хятад-Балбын хил дээр сүндэрлэх “ертөнцийн гуравдагч туйл” гэгддэг 8848 м дэлхийн хамгийн өндөр оргил Жомуланма, дэлхийд нэртэй Баруун Сибирийн тэгш тал, бараг 3 сая км² талбай бүхий дэлхийн хамгийн том Баруун Азийн Арабын хойг, дэлхийн хамгийн том 20 мянга гаруй арал бүхий Зүүн Өмнөд Азийн Малайн бүлэг арлууд Ази тивд оршдог. Мөн дэлхийн хамгийн том нуур болох Каспийн тэнгис (тэнгис нэртэй ч дэлхийн хамгийн том давст нуур), дэлхийн цэнгэг усны 20%-ийг эзлэх хамгийн гүн Байгал нуур, нэгэн зэрэг цэнгэг болоод давстай устай Балхаш нуур, давсны хэмжээ нь ердийн далайн уснаас 6 дахин илүү буюу 300% давстай дэлхийн “давсны том агуулах” гэгддэг дэлхийн хамгийн нам дор газар болох далайн түвшнээс дээш 400 м-т орших Сөнөсөн тэнгис гээд дэлхийд алдартай гол мөрөн, нуурууд Ази тивд олон бий.

Өргөн уудам Азийн эх газарт Энэтхэгээс Япон хүртэл, Монголоос Индонез хүртэл өнөө байгаа хүн ам нь дэлхийн хүн амын 60 гаруй хувь буюу 7 тэрбум хүний 4 тэрбум гаруй нь аж төрдөг. Дэлхийд 100 саяас дээш хүн амтай 11 улс байдгаас Хятад, Энэтхэг, Индонез, Япон, Бангладеш, Пакистан гэсэн 6 орон Азид орших төдийгүй дэлхийн 2000 гаруй үндэстний тал илүү хувь нь буюу 1000 гаруй нь мөн л Азид хамаарна.

Азийн соёл иргэншлийг Азийн олон орны ард түмний хамтын хөдөлмөрөөр бүтээн бий болгосон бөгөөд Евфрат–Тигр мөрөн, Инд–Ганга мөрөн, Шар-Хөх мөрний ай сав газар бол Азийн соёл иргэншлийн 3 том голомт, бүс нутагтаа төдийгүй дэлхий дахинаа асар их нөлөө үзүүлсэн эртний түүхт нутаг билээ.

Дэлхийн 3 төрлийн том арьстан Азид тархан суудаг. Дэлхийн шинжтэй Будда, Христос, Ислам гэсэн 3 шашны үүссэн нутаг Ази тив гээд Азийн бусад тивээс ялгарах онцлог түүх, соёл иргэншил бүхэн энд бий. Дэлхий гэдэг үг өнгөрсөн үед “өрнөдийн ертөнц” гэсэн утгатай байлаа. Өнөөдөр манай гаригийн гол хандлага “дорно дахин сэргэн мандаж байна” гэдэг бодит үнэнийг өрнөдийнхэн хүлээн зөвшөөрөхөөс аргагүй болж байна. Дорныхон ч, өрнийхэн ч Азижиж буй шинэ ертөнцийн зүг хүн төрөлхтөний анхаарал хандаж буйг улам бүр мэдрэх боллоо.

Дэлхийн хөгжлийн гол тэнхлэг өрнөдөөс дорно руу, Европоос Ази руу шилжиж байна. Ази тив үнэхээр дэлхийн төв болж байгааг эдийн засгийн хүчин чадал нь өдрөөс өдөрт нэмэгдэж, үүнийг дагалдаад улс төрийн хүч нөлөө нь өргөжиж, соёлын нөлөөлөх хүчин зүйл нь газар сайгүй тарж буйгаар тодорхойлж болно.

2011.12.25

Ашигласан ном зохиол

1. Л.Бэгзжав Ази-Наран ургах хязгаар “Ням гариг” сонин (“Ардын эрх”) 1997.12.28 №52 (199)
2. 最新各国概况 (亚洲) 分册 (Хамгийн шинэ, дэлхийн улсуудын байдал), (Ази тивийн лавлах) Чанчунь хот. 2007 он
3. 新版各国概况 (亚洲) (Шинээр хэвлэгдсэн, дэлхийн улсуудын байдал, Ази тив) Бээжин хот. 2012
4. 世界各国各名集锦 (Дэлхийн улс орнуудын нэрийн эмхэтгэл) Бээжин хот. 1987 он
5. 走进亚洲 (Азиар аялахуй) Чэнду хот. 2005 он
6. John Naisbitt (Америк) Megatrends ASIA. Шанхай. 1996 он
7. Атлас Мира (справочный) М, 2006 год
8. 亚洲 (Ази) Бээжин хот. 2009он
9. 神秘亚田亚 (Нууцлаг Ази) Бээжин хот. 2011 он
10. 亚洲知识地图册 (Азийн мэдлэг, газрын зургийн лавлах) Бээжин хот. 2011 он